



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/173

Булган

Агаар мандалд зориудаар
нөлөөлөх тухай

Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5.6, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт, Засгийн газрын 2007 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн нутгаар дулааны улиралд цаг агаар тогтворгүй, олон жилийн дунджаас дулаан, салхи шуурга, хуурайшилт ихтэй байгаа нь бэлчээрийн ургамлын ургац, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл, хаврын тариалалтад сөргөөр нөлөөлж болзошгүй тул үүлэнд зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх, байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилго бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: О.Гантулга /Аймгийн Засаг даргын орлогч/

Гишүүд:

- Д.Буманбаяр /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга/
- Ч.Амгалан /Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга/
- Ш.Баасандорж /Онцгой байдлын газрын дарга/
- А.Гантөмөр /Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга/
- С.Жаргалсайхан /Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга/
- Ү.Бямбасүрэн /Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга/
- Б.Батболд /Мэргэжлийн хяналтын газрын дарга/

Нарийн бичгийн дарга: С.Алтанзул /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн/

2. Байгаль, цаг агаарын бодит судалгаа, дүгнэлтэд үндэслэн шаардлагатай тохиолдолд 2017 оны 04 дүгээр сарын 04-нөөс эхлэн агаар мандалд зориудаар нөлөөлж, хур

D:\ЗДТГ\ХОХБТХ\Захирамж

20190176


тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж ажиллахыг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв /С.Жаргалсайхан/, Онцгой байдлын газар /Ш.Баасандорж/, Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ч.Амгалан/-т тус тус даалгасугай.

3. Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын баталсан “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг зохицуулах дүрэм”-ийг мөрдөж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг олон улсын болон орон нутгийн нислэгийн аюулгүй байдалтай уялдуулан зохион байгуулж, хамтран ажиллахыг Иргэний нисэхийн Ерөнхий газрын харьяа “Булган” нисэх буудлын дарга /Б.Баасанбат/, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв /С.Жаргалсайхан/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Агаар мандалд зориудаар нөлөөлөх экспедицийг тухайн орон нутагт ажиллах нөхцөл, боломжоор хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт чиглэл болгосугай.

5. Шатахуун, томилолт, үйл ажиллагааны зардлыг тухай бүр нь шийдвэрлэж ажиллахыг аймгийн Онцгой комисст хариуцуулсугай.

6. Дээрх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд төр, төсвийн байгууллага, сум, багийн Засаг дарга нарын ажлын хариуцлагыг сайжруулан, үүрэг чиглэлээр хангаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тухай бүр танилцуулахыг ажлын хэсэг /О.Гантулга/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ